



ХЭНТИЙ АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 06 сарын 16 өдөр

Дугаар 5/60

Чингис хот

Б.Оргодолыг ажилд томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, 33.4, Төрийн албаны тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1, 44.5, 57 дугаар зүйлийн 57.2, 57.2.2 дахь заалт, Улсын Их Хурлын 2019 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам”, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам”, 2019 оны “Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, жагсаалт батлах тухай” 275 дугаар тогтоолын хавсралт, “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 472 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга, Төрийн албаны зөвлөлийн даргын хамтарсан 2019 оны 34/31 дугаартай тушаалаар баталсан “Төрийн жинхэнэ албан хаагчийг өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах журам”-ын 1.5, 1.6, 2.1, 5.1-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгээ Авлигатай тэмцэх газарт хянуулж, ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал тогтоогдоогүй Санхүү, төрийн сангийн хэлтсийн Төсвийн орлого, хөрөнгө оруулалтын санхүүжилт хариуцсан ахлах мэргэжилтний албан тушаалд ажлын зайлшгүй шаардлагаар Аймгийн төсвийн ерөнхий нягтлан бодогчоор ажиллаж байсан Баатарсайханы Оргодолыг 2020 оны 6 дугаар сарын 16-ны өдрөөс эхлэн томилсугай.

2. Б.Оргодолын цалинг ТЗ-6-5 шатлалаар тогтоон үндсэн цалин 853375 /найман зуун тавин гурван мянга гурван зуун далан тав/ төгрөгөөр, төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 10, зэрэг дэвийн нэмэгдлийг 20 хувиар тооцож олгохыг нягтлан бодогч /Э.Ариунтунгалаг/-д зөвшөөрсүгэй.

3. Төсвийн орлого, хөрөнгө оруулалтын санхүүжилт хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтод заагдсан чиг үүрэг болон хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Б.Оргодолд үүрэг болгосугай.

4. Б.Оргодолд томилогдооноос хойш 30 хоногийн дотор хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгээ Төрийн захиргааны удирдлагын хэлтэс /Ж.Гантулга/-т гаргаж өгөх үүрэгтэйг сануулсугай.

5. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан 2020 оны Б/52 дугаар тушаалыг хүчингүйд тооцсугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР

231030233